


Европын Холбоотой хамтарсан Ойн Түншлэл

Ойн Түншлэл нь **Европын Холбоо** болон
түнш орнуудын **хооронд** дэлхийн **ойг
хамгаалах**, нөхөн сэргээх, тогтвортой
ашиглахад чиглэсэн урт хугацааны
бодлогын түвшний хамтын ажиллагаа юм.




#GlobalGateway
#ForOurPlanet

ОЙН ТҮНШЛЭЛ
forest.gov.mn







capacity4dev.europa.eu/groups/sustainable-forests



Ойд хөрөнгө оруулах нь

уур амьсгалын өөрчлөлттэй
тэмцэхэд чухал хөшүүрэг юм.

Ойн Түншлэл нь тухайн түнш орны тэргүүлэх чиглэл, хэрэгцээ шаардлагад нийцсэн онцлог шийдлүүдийг бүрдүүлж, эерэг үр нөлөөг бий болгохын тулд:

-  Ойн салбарыг бодлогын түвшинд чухалчилж;
-  Тогтвортой хөгжлийн зорилго 2030, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын хэлэлцээр, Биологийн олон янз байдлын конвенцийг хэрэгжүүлж;
-  Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж;
-  Ойн салбарын урт хугацааны зорилтуудад хүрэх юм.

#GlobalGateway
#ForOurPlanet

ОЙН ТҮНШЛЭЛ
forest.gov.mn



Монгол Улс-Европын Холбооны Ойн Түншлэл

Европын Холбоо нь **Ойн Түншлэлээр** дамжуулж Монгол Улсад **ногоон хөгжлийн амлалтаа** биелүүлэхэд дэмжин ажиллаж байна.



Монгол орны ой мод

Ой мод нь Монголын үндэсний үнэт зүйл, ялгарах онцлогийн гол хэсэг билээ.

Ойн тухай товч мэдээлэл

8.71%

Ойгоор бүрхэгдсэн талбай

80,000

Ойтой холбоотой ажлын байр

83.5%

(16 сая га)

Хамгаалалттай ойн талбай

0.3%

ДНБ дэх ойн салбарын эзлэх хувь

1.25%

1990 оноос хойших ойн хомсдол



Ойд суурилсан нэмүү өртгийн сүлжээ

Мод боловсруулах салбарын дотоодын нийлүүлэлтийн сүлжээ болон ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлснээр, өв уламжлалаа хадгалж, импортын хамаарлыг бууруулна. Монгол Улс ойн хамгаалал, тогтвортой менежментийг хэрэгжүүлэхээр зорьж, хөгжлийн боломжийг нээж “Тэрбум мод” тарьж байна.



Хүмүүс ба ой мод

Уламжлалт мэдлэг, үнэт зүйлсийг хариуцлагатай эдийн засгийн боломжуудтай хослуулснаар ойн экосистем болон монголчуудад харилцан үр өгөөжтэй байх болно.



ОЙН ТҮНШЛЭЛ
forest.gov.mn



#GlobalGateway
@EUinMongolia

capacity4dev.europa.eu/groups/sustainable-forests

Монгол гэр

ЮНЕСКО-гийн Хүн төрөлхтний биет бус соёлын өвд бүртгэгдсэн Монгол гэр нь өнөөдөр Монгол Улсын экспортын гол модон бүтээгдэхүүн бөгөөд жилээс жилд худалдаа, хэрэглээ нэмэгдэж буй нь нэмүү өртөг шингэсэн ойн бүтээгдэхүүний үйлдвэрлэл цаашид ч хөгжих боломжийг харуулж байна.



2030 ОНЫ ЗОРИЛТУУД

Хамгаалсан, нөхөн сэргээсэн, тогтвортой менежмент бүхий ойн талбайг нэмэгдүүлэх;

Ойн салбарт зохистой ажлын байр бий болгох, тоог нэмэгдүүлэх;

Байгалийн ойн жилд хорогдох хэмжээг бууруулах;

Ойн тогтвортой менежментийг дэмжих;

Хууль ёсны, тогтвортой мод боловсруулах үйлдвэрлэлд хөрөнгө оруулах арга замыг хөнгөвчилж, Монгол Улс-ЕХ хооронд хийж болохуйц модон бүтээгдэхүүний худалдааг дэмжинэ.

